



НИЙСЛЭЛИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 15 өдөр

Дугаар 21/77

Улаанбаатар хот

Сургалт зохион байгуулах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.6, 13 дугаар зүйлийн 13.2, 30 дугаар зүйлийн 30.1.16, 30.2, 30.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Төрийн болон төрийн бус, аж ахуйн нэгж байгууллагын ажилтан, алба хаагчдад гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт сурталчилгааны ажлыг эрчимжүүлэх, гамшгаас хамгаалах чиглэлээр мэдлэг, чадвар олгох сургалтыг 2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрөөс 09 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд нийслэлийн хэмжээнд зохион байгуулсугай.

2. Сургалтын удирдамжийг нэгдүгээр, шаардлагатай зардлын тооцоог хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Сургалт зохион байгуулахад шаардагдах 42.875.000 (дөчин хоёр сая найман зуун далан таван мянган) төгрөгийг зохих зардлаас гаргахыг Санхүү, эдийн засгийн хэлтэс (дэд хурандаа Д.Урантулга)-т зөвшөөрсүгэй.

4. Сургалтын бэлтгэлийг хангаж, хугацаанд нь зохион байгуулахыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга нарт, сургалтын явцад хяналт тавьж ажиллахыг Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэс (хурандаа Г.Нэргүй)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тэргүүн дэд дарга, дэд хурандаа Н.Нямхорлоод даалгасугай.

ДАРГА,
ХУРАНДАА

Ж.ЧҮЛТЭМСҮРЭН



Нийслэлийн Онцгой байдлын газрын даргын
2019 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн
А/А/ дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

АЮУЛТ ҮЗЭГДЭЛ ОСОЛ, ГАЛ ТҮЙМРЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
НЭГДСЭН СУРГАЛТ ЗОХИОН БАЙГУУЛАХ АЖЛЫН УДИРДАМЖ

Нэг. Зорилго

Гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалт, сурталчилгааны хүртээмжийг нэмэгдүүлэх, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх, гамшгийн үед өөрийгөө болон бусдыг хамгаалах, анхны тусламж үзүүлэх чиглэлээр иргэд, олон нийтийн мэдлэг, чадварыг дээшлүүлэхэд оршино.

Хоёр. Сургалтыг зохион байгуулах хугацаа

2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрөөс 09 дүгээр сарын 08-ны өдрийг хүртэл хугацаанд зохион байгуулна.

Гурав. Сургалтад хамрагдах бүрэлдэхүүн

Сургалтыг дүүрэгт үйл ажиллагаа явуулж буй төрийн байгууллага, хуулийн этгээдийн ажилтан, алба хаагч болон 2019 оны эхний хагас жилд гамшиг осол, гал түймрийн дуудлага олон удаа гарсан хороодын иргэдийг хамруулан гамшгаас хамгаалах "Бэлэн бай" сургалтын багцыг ашиглан зохион байгуулна. Үүнд:

д/д	Дүүрэг	Сургалтанд хамруулах хүний тоо		
		Ажилтан, албан хаагч	Иргэн	Нийт
1	Багануур дүүрэг	200	200	400
2	Багахангай дүүрэг	100	200	300
3	Баянзүрх дүүрэг	300	300	600
4	Баянгол дүүрэг	300	300	600
5	Налайх дүүрэг	300	300	600
6	Сонгинохайрхан дүүрэг	300	300	600
7	Сүхбаатар дүүрэг	300	300	600
8	Хан-Уул дүүрэг	300	300	600
9	Чингэлтэй дүүрэг	300	300	600
	Нийт	2400	2500	4900

Дөрөв. Зохион байгуулах бүрэлдэхүүн

Сургалтыг дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга, орлогч, Гал түймрийн улсын хяналтын байцаагч, Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан

мэргэжилтэн, Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн нар хамтран зохион байгуулна.

Сургалтын явц, үр дүнд Нийслэлийн Онцгой байдлын газрын Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтсийн дарга, мэргэжилтнүүд хяналт тавьж ажиллана.

Тав. Сургалтын хөтөлбөр

Эхлэх дуусах цаг	Сэдэв	Хугацаа	Хариуцах албан тушаалтан
08:45-09:00	Бүртгэл	15 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
09:00-09:30	Гамшгийн тухай ерөнхий ойлголт	30 минут	Дүүргийн ОБХ-ийн орлогч, ГХТББХАМ, ахлах байцаагч
09:30-10:00	Нийслэл, дүүрэгт гарч буй гамшиг осол, гал түймрийн шалтгаан нөхцөл, гамшгийн эрсдэлийг бууруулах арга хэмжээ	30 минут	Дүүргийн ОБХ-ийн Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
10:15-11:05	Үер, усны аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ / "Бэлэн бай" сургалтын багцын "Үер" сэдвээр/	50 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
11:05-11:35	Галын аюулгүй байдлын тухай хуулиар аж ахуйн нэгж байгууллагын удирдлага, иргэний хүлээсэн үүрэг	30 минут	Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн Гал түймрийн улсын хяналтын байцаагч
11:35-12:25	Объектын гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ "Бэлэн бай" сургалтын багцын "Гал түймэр" сэдвээр/	50 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
12:25-13:15	Үдийн хоол	50 минут	ОБХ-ээс томилогдсон алба хаагч
13:15-14:05	Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ /"Бэлэн бай" сургалтын багцын "Ой, хээрийн түймэр" сэдвээр/	50 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
14:05-14:55	Мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах арга хэмжээ	50 минут	Дүүргийн ОБХ-ийн Эрсдэлийн удирдлага, үнэлгээ, дотоод ажил хариуцсан мэргэжилтэн
14:55-16:05	Живэх, түлэгдэх үеийн анхны тусламж, зүрх уушгины сэхээн	60 минут	Дүүргийн ОБХ-ийн Сургалт, сурталчилгаа, урьдчилан

	амьдруулалт /"Бэлэн бай" сургалтын багцын "Анхны тусламж" дэд хэсгээр/		сэргийлэх асуудал хариуцсан мэргэжилтэн
16:05-16:15	Цайны завсарлага	10 минут	Томилогдсон алба хаагч
16:15-17:00	Сургалтын дүгнэлт ярилцлага	45 минут	Сургалтанд оролцогчид

Зургаа. Тайлан мэдээ ирүүлэх

Удирдамжийн дагуу зохион байгуулсан сургалтын нэгдсэн илтгэх хуудсыг файлаар 2019 оны 9 дүгээр сарын 11-ний өдөрт багтаан nobg.surgalt@gmail.com хаягаар, Онцгой байдлын хэлтсийн даргын баталгаажуулсан хувийг 9 дүгээр сарын 12-ны өдөр хэвлэмэлээр тус тус Гамшгаас урьдчилан сэргийлэх хэлтэст ирүүлнэ.

---oOo---